

4.1 Төгсөлт баталгаажуулах/цуцлах

Төгсөлт баталгаажуулах/цуцлах

Энэ үйлдлийг бүлгийн нийт суралцагчдын төгсөлтийн бүртгэлийг баталгаажуулах/ цуцлах үед ашиглана.

ТӨГСӨЛТ БАТАЛГААЖУУЛАХ/ЦУЦЛАХААС ӨМНӨ ДАРААХ АЖЛУУД СИСТЕМД ХИЙГДСЭН БАЙХ ШААРДЛАГАТАЙ.

1. Суралцагчийн төгсөлтийн бүртгэл хийсэн байх
2. Зөвхөн баталгаажуулсан төгсөлтийг цуцлах боломжтой.

Боловсолын газар сургуулийн илгээсэн суралцагчийн төгсөлтийг баталгаажуулах/цуцлах үйлдэл хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. **Төгсөлтийн нэгтгэл** үйл ажиллагааг сонгоно.
2. Төгсөлт баталгаажуулах/цуцлах бүлгийн харьяалагдах сургуулийг сонгоно.
3. Төгсөлтийн бүртгэл баталгаажуулах суралцагчийг чеклээд **Баталгаажуулах** товч дарна.

Суралцагчийн төгсөлтийг баталгаажуулах/цуцлах алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Төгсөлтийн нэгтгэл**-ийг сонгоход дараах цонх нээгдэнэ.

Төгсөлт нэгтгэл цонхны зүүн хэсэгт байрлах талбараас төгсөлтийн баталгаажуулалт / цуцлалт хийх бүлгийн харьяалагдах сургуулийг сонгоход баталгаажуулах дараах цонх нээгдэнэ.

Төгсөлт баталгаажуулах/цуцлах бүлгийн харьяалагдах сургуулийг сонгон, бүлгийн мэдээллийг сонгоно.

Тус жагсаалтны дээр байрлах **Баталгаажуулах/Буцаах** товчийг дарснаас Төгсөлт баталгаажуулах/цуцлах цонх дуудагдана.

Бүлэг 9-а (9-р анги Суурь боловсролын өдрийн хөтөлбөр /Ердийн/)

Сонгон суралцагч : 0 / 30

№	☐	Суралцагч	Регистр	Шийдвэр	Огноо	Баримт бичиг	Төлөв
26		Б.Минжинсор		Төгсгөх	2018-05-21		Бүртгүүлсэн
27		С.Минжинсор		Төгсгөх	2018-05-21		Бүртгүүлсэн
28		Э.Баттөгс		Давтан суралцу...	2018-05-21		Бүртгүүлсэн
29		Э.Баттөр		Давтан суралцу...	2018-05-21		Бүртгүүлсэн
30	☐	Б.Адилсүх		Төгсгөх	2018-05-21		Хянагдаж байгаа

Хуудас 2 - 2 (30 бичлэгээс 26 - 30) К < 1 2 > Ж

Тийм

Болих

Тус жагсаалтаас хянагдаж буй төлөвтэй суралцагчийг сонгон, Тийм товч дарснаар төгсөлтийн бүртгэлийг баталгаажуулна/цуцлана.